

## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХИ ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ТУХАЙ

/ЗӨВЛӨМЖ/

2004 оны 04 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

Улсын Дээд шүүхийн Судалгааны төвөөс Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаанаар 2003 оны 10 дугаар сараас 2004 оны 1 дүгээр улирлыг дуустал хугацаанд хянаж шийдвэрлэсэн 275 тогтоолыг уншиж, шүүхийн практик судаллаа. Эдгээр 275 тогтоолын 15 нь цагаатгалын хэрэг байна.

Судалгааны зорилго нь шинэ Эрүүгийн хууль, Эрүүгийн Байцаан шийтгэх хуулиудыг шүүхийн практикт хэрэглэж хэвшиж байгаа байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй нийтлэг алдаа, зөрчил дутагдлуудыг дахин давтан гаргахгүй байхад чиглэгдсэн болно. Дээрхи хугацаанд нийт 417 шүүгдэгчид холбогдох 260 эрүүгийн хэрэг хянагдсан ба эдгээрийг аймгуудаар нь үзүүлбэл: Архангай 3, Баянхонгор 2, Баян-Өлгий 4, Булган 9, Говь-Алтай 12, Говьсүмбэр 5, Дархан-Уул 12, Дорнод 12, Дундговь 1, Дорноговь 7, Завхан 6, Орхон 4, Өмнөговь 4, Сүхбаатар 3, Сэлэнгэ 14, Төв 13, Увс 8, Хэнтий 9, Ховд 7, Хөвсгөл 9, Нийслэл, дүүргийн шүүхүүдийн 110 эрүүгийн хэргийг тус тус хянаж шийдвэрлэсэн байна.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас 260 эрүүгийн хэргийг хянаад 125 хэргийн тогтоолыг хэвээр үлдээсэн нь нийт хянагдсан хэргийн 48,0 хувийг, 53 эрүүгийн хэргийн тогтоолыг хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 20,3 хувь, 78 хэргийн тогтоолд өөрчлөлт оруулсан нь нийт хянагдсан хэргийн 30 хувийг эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлал доорхи шалтгаанаар өөрчлөгдөж, хүчингүй болж байна.

### **Нэг. Эрүүгийн хуулийг хэрэглэх талаар.**

Сум болон сум дунд дүүргийн шүүхээс гаргаж буй нийтлэг алдаанууд:

#### **1. Хэргийн зүйлчлэлийг хууль зүйн үндэслэлгүйгээр өөрчлөх явдал нэлээд түгээмэл байна.**

Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн бусад гэмт хэргээс ялгалгүй хутга мээ хэрэглэсэн л бол Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсэгт зааснаар зүйлчлэх ёстой мэт дүгнэж хэргийн болон гэмт этгээдийн гэм буруугийн сэдэлт, зорилго зэрэг субъектив талын шинжүүдэд нь ач холбогдол өгөхгүйгээр буруу дүгнэлт хийж, хуулийг буруу хэрэглэж байна.

Мөн шүүхүүд Прокуророос танхайн гэмт хэргээр зүйлчлэн ирүүлсэн хэргийг Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйл болгон зүйлчлэлийг өөрчлөхдөө эдгээр хоёр төрлийн гэмт хэргийн субъектив талын шинжийг ялгаж чадахгүй зүйлчлэлийг үндэслэлгүйгээр өөрчилдөг дутагдал бараг бүх шүүх дээр байна.

Жишээ нь: Шүүгдэгч Ж.Жаргалсайхан нь 2003 оны 1 дүгээр сард иргэн Гантөмөрийн зүүн гуянд хутгалж хөнгөн гэмтэл учруулсан хэрэгт Баянзүрх дүүргийн шүүх 2003 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 243 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-д зааснаар 5 жил 10 хоногийн хугацаагаар хорих ял шийтгэсэн байна. Хохирогч Гантөмөр нь Жаргалсайханыг шаварт унаган, тулхэх, тонгорох зэргээр өдсөнөөс шүүгдэгч Жаргалсайхан нь хувийн сэдэлтээр түүнийг хутгалсан үйлдэл нь танхайн гэмт хэрэг биш бөгөөд Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлд зааснаар зүйлчлэх ёстой байжээ.

Өвөрхангай аймаг дахь сум дундын шүүхийн 2003 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 148 дугаар шийтгэх тогтоолоор А.Бямбажав гэгч нь 1996-2002 онуудад өөрийн эхнэр Н.Батжаргалыг удаа дараа зодож, хутга шидэн, өвдгийг нь гэмтээх, буу барьж айлган сүрдүүлэх зэргээр танхайрч хөнгөн гэмтэл учруулсан, 2003 оны 3 дугаар сарын 20-ны өдөр бэр Отгонсүрэнг ээжийгээ зодлоо гэж марган, толгойн тус газар нь гараараа цохин биед нь хүнд гэмтэл учруулан амь насыг нь хохироосон гэмт хэргүүдийг тус тус үйлджээ.

Прокуророос Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгээр зүйлчилж ирүүлснийг шүүх Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 болгон хөнгөрүүлэн зүйлчилж ял шийтгэсэн байна. Шүүгдэгч Бямбажав нь бусад руу хутга шидэх, буу зэвсэг барьж айлган сүрдүүлэх зэргээр удаа дараа танхайрсан байхад шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна.

Түүнчлэн шүүхүүд бусад төрлийн гэмт хэргийн зүйлчлэлийг ч хууль зүйн үндэслэлгүй өөрчилдөг алдааг гаргасаар байн=а. Тухайлбал: 2003 оны 10 дугаар сарын 26-ны шөнө Бат-Өрнөх, Ихбаясгалан гэгч этгээдууд нь бүлэглэн иргэн А.Чинбатын хоолойг боох, цохих зэргээр хүч хэрэглэн довтолж, өмсөж явсан савхин хүрэм, зүүж явсан мөнгөн бөгжийг дээрэмдэж авсан гэмт хэрэг үйлдсэн байхад Чингэлтэй дүүргийн шүүх 2004 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 48 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 147.2-оор яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг мөн хуулийн 146 дугаар зүйлийн 146.2 болгон хөнгөрүүлэн өөрчилж, хөнгөн ял шийтгэсэн нь буруу байна.

## **2. Зарим шүүх хуулийг илт буруу хэрэглэн шүүгдэгчид ял завшуулж байна.**

Жишээ нь: Дорноговь аймаг дахь сум дундын шүүх 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 61 дүгээр шийтгэх тогтоолоор Б.Ариунсайхан гэгч нь эрүүгийн төлөөлөгчөөр ажиллаж бэйхдаа 2002 оны 8 дугаар сард эрүүгийн хэрэгт шалгагдаж байсан Ц.Батмөнхөөс барьцаанд 150000 төгрөг, 2002 оны 10 дугаар сард эрүүгийн хэрэгт сэжигтнээр шалгагдаж байсан Д.Саранцэцэгээс 100000 төгрөгийг торгуулийн мөнгө болгон хувьдаа авч албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж завшсан, 2002 оны 12 дугаар сард Оюунчимэгээс өмгөөлөгч олж өгнө гэж 100000 төгрөгийг залилан авсан гэмт хэргүүдийг үйлдсэн бөгөөд түүний үйлдсэн хэргүүд нотлогдсон байхад шүүх «нийлмэл гэмт хэрэг» гэж үзэн ЭБШХ-ийн 208 дугаар зүйлийн 208.1-д зааснаар Саранцэцэгээс 100000 төгрөг авсан гэх үйлдлийг хэрэгсэхгүй бопгож, Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.2, мөн хуулийн 12 дугаар зүйлийг баримтлан 150 дугаар зүйлийн 150.2 дахь хэсгээр яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, ЭБШХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1, 208 дугаар зүйлийн 208.1.3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Ариунсайханы үйлдсэн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж, хуулийг илт буруу хэрэглэн шүүгдэгчид ял шийтгэл завшуулсан байна.

Мөн Баянхонгор аймаг дахь сум дундын шүүх 2003 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 136 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Б.Базарханд, Б.Ганболд, Ц.Пүрэвсүрэн нар нь бүлэглэн иргэн Б-гийн бэлчээрт байсан нэг тэмээг хулгайлан 120000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн, тэдний үйлдсэн гэмт хэрэг нотлогдсон байхад Базархандын иргэн Б-гийн тэмээ хулгайлан нядалсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-оор яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг хэрэгсэхгүй болгон, 145 дугаар зүйлийн 145.1 болгон, мөн зүйлээр торгох ял шийтгэн, Пүрэвсүрэн Ганболд нар нь Базархандтай бүлэглэн тэмээ хулгай хийсэн үйлдэлд Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй байх тул ЭБШХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-ээр эдгээр хоёр шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон ял завшуулсан байна.

**3. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан япын хэмжээг хугацаа тоолох журмын хувьд зөв хэрэглэж чадахгүй байна.**

Тухайлбал: Орхон аймаг дахь сум дундын шүүх 2003 оны 1 дүгээр сарын 23-ны 17 дугаар шийтгэх тогтоолоор У.Шархүү нь иргэн Чг хутгалсан. иргэн Шаравыг цохиж хөнгөн зэргийн гэмтэл учруулсан хэрэгт 5 жилийн хорих ял оногдуулж, Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-д заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд «5-аас дээш 8 жил хүртэл хугацаагаар» хорих ял оногдуулах заалтыг зөрчсөн, мөн шүүхийн 2003 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 116 дугаар шийтгэх тогтоолоор А.Жаргалсайхан гэгчид ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэгт «10-аас дээш» гэж заасан байхад 10 жилийн хорих ял оногдуулан хууль буруу хэрэглэсэн байна.

**4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим зүйл хэсэгт нэмэгдэл ял заавал хэрэглэх эсхүл хэрэглэх буюу хэрэглэхгүйгээр ял шийтгэл оногдуулж байхаар заасан байхад нэмэгдэл ялын асуудлыг шийдвэрлэхгүйгээр орхиж байна.**

Тухайлбал: Өмнөговь аймаг дахь сум дундын шүүх 2003 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 110 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Д.Будад Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар ял шийтгэл оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-д заасан «эд хөрөнгийг заавал хураах»-аар заасан заалтыг хэрэглээгүй байна.

**Анхан шатны шүүхээс хэрэгт цугларсан нотлох баримтуудад үнэлэлт дүгнэлт өгч бүрэн шийдвэрлэх боломжтой байхад үндэслэлгүйгээр нэмэлт мөрдөн байцаалтад буцааж байна.**

Жишээ нь: 2003 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 46 дугаар шийтгэх тогтоолтой С.Жамбалдорж, С.Гүрбазар нарт холбогдох хэргийг хавтаст хэрэгт авагдсан баримтуудаар шийдэх бүрэн боломжтой байхад Төв аймгийн шүүх үндэслэл муутай дүгнэлт хийж уг хэргийг мөрдөн байцаалтад буцаажээ. Энэ дутагдлыг олон шүүх гаргасан байна.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн тогтоолыг үндэслэлгүйгээр өөрчилдөг дутагдал цөөнгүй гарч байна.

1.Говь-Алтай аймгийн сум дундын шүүхийн 2003 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 58 дугаар шийтгэх тогтоолоор А.Нэргүй гэгч нь иргэн Эрдэнэгэрэлийн хэвлийн тус газар өшиглөн санаатайгаар хүнд гэмтэл учруулсан үйлдэлд нь шүүх Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-ээр 5 жил 1 сарын хорих ял оногдуулан хэргийг зөв зүйлчилж, хуулинд заасан ял шийтгэл оногдуулсан байхад Говь-Алтай аймгийн шүүх 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 25 дугаар магадлалаар «хохилогчийн буруутай үйл ажиллагаанаас болж Нэргүй нь хохирогчид хүнд гэмтэл учруулсан, уг хор уршигт санаатай хүргээгүй, мөн түүний үйлдлийн улмаас шууд шаптгаалан хохирогч нас бараагүй» гэсэн хууль зүйн үндэслэлгүй дүгнэлт хийж, хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилсөн байна.

2.Давж заалдах шатны шүүхээс хэргийн бодит байдалд үндэслэл муутай дүгнэлт хийн, анхан шатны шүүхээс зөв шийдвэрлэсэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчлөх, хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол түгээмэл байна. Тухайлбал: Я.Дашбилэг гэгчид 2003 оны 7 сарын 26-ны өдөр ах Дашцэрэнгийнхээ чингэлгээс 100000 төгрөг, 8 дугаар сарын 13-нд 400000 төгрөг хулгайлан авсан гэмт хэргүүдэд Өвөрхангай аймгийн сум дундын шүүх 2003 оны 9 дүгээр сарын 15-ны 1/100 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-оор 6 сарын баривчлах ял шийтгэсэн байна. Дашбилэгийн хулгайн хэргийн 2 үйлдэл нь тусдаа санаа зорилготой, давтан гэмт хэрэг ба энэ хэргийг үйлдэхдээ хохирогчийн агуулах саванд нэвтэрч үйлдсэн нь нотлогдсон байхад Өвөрхангай аймгийн шүүх 2003 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 36 дугаар магадлалаар хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 болгон хөнгөрүүлэн өөрчилж, хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Түүнчлэн 3.Гүнчин-Иш гэгчийн 2002 оны 5 дугаар сард өөрийн эхнэр Мянгансүвдыг жирэмсэн гэдгийг мэдсээр байж санаатай алсан үйлдэлд нь Чингэлтэй дүүргийн шүүх

2003 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 149 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.14-д зааснаар 17 жилийн хорих ял оногдуулан шийдвэрлэсэн байхад Нийслэлийн шүүх 2003 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 384 дүгээр магадлалаар зүйлчлэлийг 1986 оны Эрүүгийн хуулийн 90 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болгон үндэслэлгүйгээр хөнгөрүүлэн өөрчилсөн байна.

3. Давж заалдах шатны шүүхээс давж заалдах шатны шүүх хуралдаанд өмгөөлөгчийн гомдлыг танилцуулдаггүй, хуралдаанд оролцсон өмгөөлөгчийн саналын үндэслэлийг магадлалд зөв тусгахгүй байх зэрэг зөрчлүүдийг гаргажээ,

### **Хоёр. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх тзлаар.**

1. ЭБШХуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчиж байна, Тухайлбал: Орхон аймаг дахь сум дундын шүүхийн 2003 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 116 дугаар шийтгэх тогтоолоор А.Жаргалсайхан гэгчид Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсгээр ял оноохдоо ЭБШХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт заасан онц хүнд, хүнд гэмт хэрэгт 3 иргэдийн төлөөлөгч оролцуулах заалтыг ноцтой зөрчсөн, Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэгт «... 10-аас дээш ...» гэж заасан байхад 10 жилийн хорих ялаар шийтгэж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэжээ.

2. Булган аймгийн сум дундын шүүх 2003 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 101 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.2-4 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн шүүгдэгч Д.Идэрхангайд холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэрлэсэн атлаа тогтоол /шийтгэх тогтоол гаргах ёстой байсан/ гаргаж ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн, Идэрхангайд хопбогдох хэргийн ял шалгах хуудсанд « 2001.5.25, Булган, сум дундын шүүх, хоёр жил тэнсэв » гэж бичсэн нь ойлгомжгүй байна.

3. Говь-Алтай аймгийн сум дундын шүүх 2002 оны 1 дүгээр сарын 25-ны 12 дугаар шийтгэх тогтоолоор Д.Наранцацралт нарын 12 шүүгдэгч нь Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 2,194,192 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэрэг үйлдсэн ба шүүх хэргийг зөв зүйлчилж, хуулинд заасан ял шийтгэлийг оногдуулсан байна. Харин хохирлын асуудлыг шийдвэрлэхдээ банкны байгууллагыг хариуцагчаар татаж эхний удаад байгууллагаас гаргаагүй нь 1964 оны Иргэний хуулийн 378 дугаар зүйлийн заалтыг зөрчсөн, түүнчлэн иргэний нэхэмжлэгчээр тогтоогдож байцаагдсан нэхэмжлэгчид хавтаст хэргийн нэхэмжлэлтэй холбогдох хэсэггүй танилцуулж, шүүх хуралдаанд оролцуулах арга хэмжээ аваагүй зэрэг ЭБШХ-ийн заалтуудыг зөрчсөн байна.

4.ЭБШХ-ийн 318 дугаар зүйлийн 318.2.2 дахь хэсэгт яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг бүрэн гүйцэд тогтоож байхаар заасан заалтыг тэр бүр биелүүлэхгүй байна. Жишээ нь: Шүүгдэгч.С.Хөхөө нь Эрүүгийн хуулийн 99, 91 дүгээр зүйлийн 91.2.12 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэн цаазаар авах ял шийтгүүлсэн байхад онцгой ял, цаазаар авах ял шийтгүүлсэн гэмт хэрэгтний хувийн байдлыг он дараалан тогтоож, түүнийг мэдэх гэрч нарыг байцаагаагүй байсан алдааг гаргаж ЭБШХ-ийг зөрчсөн байна.

Дээр дурдсан алдаа зөрчлүүдийг дахин давтан гаргахгүй ажиллаж, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхим, Шүүхийн Судалгааны Төвөөс 2003 оны 9 дүгээр сарын 10-нд гаргасан зөвлөмжийг уншин судалж, нэг төрлийн алдааг дахин давтан гаргаж байгаадаа дүгнэлт хийж ажиллахыг Аймаг, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нарт үүрэг болгож байна.

Судалгааг үндэслэн Эрүүгийн хууль, Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийг шүүхийн практикт хэрэглэхэд гарч буй алдаа, зөрчлийг арилгах, нэгдсэн ойлголт тогтоох зорилгоор Зөвлөмжлөх нь:

1. УДШ-ийн хууль тайлбарласан тогтоолууд, Эрүүгийн хэргийн танхим, ШС Төвөөс гаргаж буй тойм, зөвлөмжийн заалтуудыг ажил хэрэг болгон, сайтар судалж, шүүн таслах ажилдаа хэрэгжүүлж ажиллах.

2. Эрүүгийн хуулийн зүйл ангийг хууль зүйн үндэслэлгүйгээр хөнгөрүүлэн өөрчлөх, хэргийг хэрэгсэхгүй болгох, шүүгдэгч нарын гэм бурууд тохироогүй илт хөнгөн ял шийтгэх явдлыг таслан зогсоох.

3. Урьд нь ял шийтгэгдсэн этгээдийн ял шийтгэлийн байдал болон гэмт хэрэгтний хувийн байдлыг ЭБШХ-ийн 318 дугаар 318.2.2-д зааснаар бүрэн гүйцэд тогтоон, шийтгэх тогтоолын удиртгал хэсэгт ойлгомжтой, тодорхой бичиж байх.

4. Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвөөс гаргаж буй зөвлөмжүүдийн зорилго нь шүүгч та бүхнийг гаргасан алдаа зөрчлөө дахин давтан гаргахгүй байхад чиглэж байгаа бөгөөд тус төвөөс гаргаж буй тойм, зөвлөмжүүдийг шүүн таслах ажилдаа аль болох хэрэглэж ажиллахыг Та бүхэнд зөвлөж байна.

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ  
ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ**